



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/80

Бөхт

Байгаль хамгаалах сангаас хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.1.13, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.3, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5, 3.5.4 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 98 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий агнуурын зохион байгуулалтын ажлыг хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах менежментийн төлөвлөгөө боловсруулахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Байгаль хамгаалах сангийн 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Сайхантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох баримтыг бүрдүүлж, санхүүгийн гүйлгээ хийхийг нягтлан бодогч (Б.Сайхантуяа), санхүүгийн баримтыг бүрдүүлэхийг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Баянмөнх), нярав (Т.Батбилэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ